



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,  
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,  
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2021. 02. 09 № А-1/277  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН  
ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Мэдээ, тайлан ирүүлэх тухай

Үндэсний статистикийн хорооны даргын 2016 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар олгосон зөвшөөрлийн дагуу Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар төрийн өмчийн мэдээллийн болон захиргааны статистикийн мэдээ, тайлангийн маягтуудыг баталсан.

Иймд дээр дурдсан 2 төрлийн маягтуудаас манай байгууллагад дараах маягт, мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлдэг. Үүнд:

1. **Маягт-11** -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 2020 оны жилийн дэлгэрэнгүй тайлан
2. **Маягт ТӨ-1** -Дуусаагүй барилга байгууламжийн 2020 оны жилийн мэдээ
3. **Маягт ТӨ-2** -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 2020 оны жилийн мэдээ /хураангуй тайлан/
4. **Маягт ТӨ-3** –Биет бус хөрөнгийн бүртгэлийн 2020 оны жилийн мэдээ
5. **Маягт ТӨ-5** – Үнэт зүйлсийн 2020 оны жилийн мэдээ
6. **Маягт ТӨ-6**–Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үндсэн хөрөнгийн 2020 оны жилийн мэдээ
7. **Маягт ТӨ-7** – Гадаадын зээлийн эх үүсвэрээр бий болсон үндсэн хөрөнгийн 2020 оны мэдээ
8. **Маягт ТӨ-8.1** Гадаадын буцалтгүй тусламж, хандив бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 2020 оны жилийн мэдээ
9. **Маягт ТӨ-8.2** Дотоодын буцалтгүй тусламж, хандив бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 2020 оны жилийн мэдээ
10. **Маягт ТӨ-13.1** – Улсын чанартай автозамын 2020 оны жилийн мэдээ
11. **Маягт ТӨ-13.2** – Улсын чанартай гүүрийн 2020 оны жилийн мэдээ
12. **Маягт ТӨ-14** – Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2020 оны жилийн мэдээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эдгээр мэдээ, тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 10-нд Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх үүрэгтэй тул 4 дүгээр сарын 01-ний тайлан мэдээгээ аудитлагдсан санхүүгийн тайлангийн хамт цаг хугацаанд нь ирүүлэхийг хүсье.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

13204430

A-4/2021